

Манмин Мэдээ

№ 53 2014 оны 12 сарын 7

Дэлхийн хязгаарт орших Израйль руу хандсан Бурханы хайр



“Израйльд Христийн сайн мэдээ түгээлт шинээр дахин сэргэж, илүү их ухаарч, үйлчлэлээ маш идэвхитэй хийж байгаа билээ. Энэ бүх амжилтанд хүрэхэд Доктор И Жей руг пасторын сэтгэл харамгүй тусламж дэмжлэг, хайраар л боломжтой болсон юм. Бурхан И Жей руг пасторыг өөрийн сонгосон ард түмэн Израйль руу илгээсэн гэдэгт бид чин сэтгэлээсээ итгэдэг” гэж “Еврейчүүдийн Титэм” сүмийн Шлом Абрамов пастор ийнхүү хэлсэн юм.

Израйльд тасралтгүй үр жимс гаргаж байгаа Кристал Форум

1982 онд сүм анх нээгдсэнээс хойш Израйлын төлөө тасралтгүй залбирсаар ирсэн И Жей руг пастор нь 2007 оны 7-р сараас эхлэн сайн мэдээ эхлэл болох Израйльд арав гаруй удаа очин сайн мэдээг тарааж эхлэсэн билээ.

2009 оны 9-р сард И Жей руг пастор нь Кристал Фориумын (Израйлийн пасторуудын холбоо) зохион байгуулсан Израйлийн Нэгдсэн их цуглааны номлогчоор уригдаж Иерусалимын Олон Улсын соёлын төвд Есүс бол цорын ганц Аврагч Эзэн мөн хэмээн тунхаглан сургаалыг эрч хүчтэйгээр зарлан тунхаглагласан юм.

Номлолын дараа өвчин эдгээх залбирал хийхэд оролцсон үй олон хүн өвчнөөсөө эдгэрч, эдгэрсэнээ гэрчлэн ярьж байлаа. Энэ цуглаан Оросын ТВN, Энглесе, CNL, Дижитал Конго гэх мэт телевизийн 33 сувгаар болон дэлхийн 220 гаруй оронд шууд дамжуулан цацаж байсан.

Израйлийн ард түмний дийлэнх хувь нь Эзэн Бурхан бол цорын ганц Бурхан хэмээн үздэг Иудейн шашин ноёрхсон энэ газарт цөөн хэдэн итгэгчдийг нийгмээс тусгаарлан, хавчин гадуурхдаг байсан ч Нэгдсэн их цуглаан хийсэнээс хойш Кристал Фориумын

нэр дор маш олон төрлийн үйлчлэл явагдаж, дахин сэргэсэн байна. Кристал Фориум нэртэй Израйлийн пасторуудын холбоо нь И Жей руг пасторын Израйльд тасралтгүй хийсэн үйлчлэлийн үр дүнгээр бий болсон билээ.

Кристал Фориум нь олон төрлийн үйлчлэлүүдийг зохион байгуулж байна

Кристал Фориумын зохион байгуулагч Олег Хазин пастор “2009 оны Израйлийн эдгэрлийн гайхамшиг биднийг ариун зар сайн мэдээг Израйльд итгэл дүүрэн номлож чадна гэдгийг ухааруулж өгсөн. Түүнээс хойш бид эдгэрлийн цуглаан, хөгжмийн фестивал, хүүхдийн кемп, пасторуудын цуглаан, хосуудын семинар, залбирлын цуглаан гэх мэт маш олон үйлчлэлийг хийсэн.”

Хайфагийн Хааны Алдар Сүмийн пастор Даниел Матиаш Израйлийн сүмүүдийн сэргэлтийн талаар өөрийн сэтгэгдлээ ингэж хэлсэн юм “Өнгөрсөн хэдхэн жилд Кристал Фориумын сүмүүд сүнслэг болоод тоо хэмжээ нь хүртэл асар их хурдацтай өссөн. Жил бүр маш олон хүн Христийн бие болж байгаагаа бүртгүүсэн. Түүгээр ч зогсоогүй АНУ, Герман, Эстон, Латви, Литва, Украйнь, Орос, Казакстан, мөн Азийн олон оронд дэлхийн хэмжээнд зохиогдож байна” гэж баяр хөөрөөр дүүрэн ярьж байлаа.

Пасторууд нэгдэж, Христэд итгэгчдийн нийгмийн байдал сайжирсан

Кристал Фориум жил бүр Кристал Хөгжмийн фестивалийг Манмин Төв Сүмийн Пасторуудын холбооны ерөнхий удирдагч И Сү жин пастортой хамт хийдэг болсон. Тус Фестиваль нь олон нийтийн өмнө маш зоригтойгоор Эзэнийг магтан алдаршуулан

бүжиглэж, Манмин Төв Сүмийн Урлагын багийг урин уг тоглолтыг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэн явуулдаг билээ. 2014 оны 5 сард Хайфад болсон Фестивальд ойролцоогоор 1000 орчим хүн Израйль, Орос, Украйнь, Филиппин, Финланд, Хонг Конгоос ирж оролцсоныг дэлхийн 180 гаруй оронд шууд дамжуулан цацсан билээ.

Дмитри Петровский пастор “энэ газар еврей итгэгч нартай хамт Бурханыг алдаршуулж байгаа нь үнэхээрийн гайхамшигтай байна. Израйльд Христэд итгэгчдийн нийгэмд эзлэх байр суурь өндөр болж, манай пасторууд ч улам бүр нэгдэхэд их тус дэм болсон.” гэж ярилаа.

Израйль пасторууд сүнснийхээ өсөлтийн төлөө жил бүр Манмин Төв Сүмд зочилдог

Израйль пасторууд болон итгэгчид GCN (www.gcntv.org), Оросын ТВN, Ариун Бурхан TV, Родной TV гэх мэт телевизийн сувгуудаар болон Интернетээр сургаал сонсож, Тэргүүн Пасторын номнуудаас уншиж итгэлээ өсгөж байна. Зарим хүмүүс сүмийн сүнслэг урсгалтай нэгдэхээр зуны кемп, удирдагчдын семинарт оролцдог.

Израйлийн Хааны Алдар гэдэг сүмийн пастор Орен Лев Ари 2014 оны Еврей 10:22 ‘Төгс Сүнс’ гэсэн сэдэвтэй удирдагчдын семинарт оролцсон байна. Тэр “Солонгост семинарын үеэр сонссон сургаалынхаа дагуу Бурханы хүслээр амьдрахыг хичээж байгаа. И Жей руг пастор хурдан гэм нүглээ хаяж хүчирхэг пастор болохын төлөө залбирч өгөхөд нулимс асаруулан талархаж байсан” гэж яриу.

Израйльд харуулсан Бурханы агуу хайр бүх үндэстний төлөө байгаа билээ. Манмины Израйльд хийсэн үйлчлэлээр дамжуулан арвин их үр жимсийг гаргасан Бурханд бүх алдар магтаалыг өргөж байна.

Ялгаварладаггүй, хоёр нүүр гаргахгүй байх нь мэргэн ухаан мөн

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



И Жей руг пастор

Хэт туйлширдаг болон тогтсон үзэл санаатай хүмүүс огт үнэн биш зүйлийн тухай яг жинхэнэ үнэн мэт баттай байх тохиолдол байдаг. Энэ мэт зүрх сэтгэл, бодол санаа нэг тал руу нь хэлбийж, хувирахыг туйлшрал хэмээн нэрлэдэг. Энэ төрлийн байдал нь худал хуурмаг гарахын эхлэл юм. Хэнтэй ч уулзсан, иймэрхүү ямар ч нөхцөлд хоёр нүүр гаргах юмуу худал хуурмаг сэтгэл байхгүй байж л үнэн рүү илүү ойрхон болдог. Ингэж л үйлдвэл бид сая үзэсгэлэнтэй сайхан сэтгэлтэй болж энэхүү мэргэн ухааныг олж авч чадна.

Ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй мэргэн ухааныг олж авахын тулд бид яг юу хийх ёстой вэ?

1. Ялгаварлах, болон хоёр нүүр гаргахгүй байхын тулд хайр ба энэрэнгүй сэтгэл хэрэгтэй

‘Ялгаварлахгүй байх’ гэдэг нь бүх зүйлд хоёр нүүр гаргалгүйгээр шударга байхыг хэлнэ. Хэзээ ямагт нэг тийш хэлбийлгүй хоёр нүүр гаргахгүй байвал хэнтэй ч харьцсан бүх хүнтэй ижил тэгш шударга хандаж чадна. Гадна төрх, санхүүгийн байдал, боловсрол мэдлэг гэх мэт янз бүрийн нөхцөл байдалаас болж хандах хандлага нь хувирахгүй байж чаддаг. Юу ч хийсэн ялгаварлах сэтгэл байхгүй байхын тулд эхлээд хайр, энэрэл, нигүүлслийг дотроо бий болгож, суулгах хэрэгтэй.

Бурханы Үгийг хичнээн их мэддэг байлаа ч хайрлаж, нигүүлсэх сэтгэлгүй л бол бид хэзээ ч хэрэгжүүлж чадахгүй. Жишээ нь, ‘дайснаа хүртэл хайрла’ гэж Бурхан бидэнд айлдсан ч харин яг амьдрал дээр надад хор хохирол учруулаад байгаа, ердөө ч ойлголцдоггүй хүмүүсийг хайрлана гэдэг үнэхээр хэцүү байдаг. Яагаад гэвэл бид бусдыг өөрийнхөө ойлголтоор, өөрийн зан араншин, өөрийн зүгээс хардаг учраас тэр юм. Хайр, нигүүлсэл дутуу байгаа учраас

бусадтай санаа нийлэхгүй үед амархан гомдож, хурдан шүүж дүгнэх гээд байдаг.

Адилхан хүнийг өсгөдөг линз зүүгээд харвал тарган харагддаг харин жижигрүүлдэг линз зүүчихвэл туранхай харагддаг. Хэрэв бид түүнийг зүүсэн шилнээсээ болоод тарган, туранхай гэж хэлвэл юу болох вэ? Та харж байгаагаа л хэлж байж магадгүй гэвч энэ нь яг бодит байдлаас тэс өөр учраас худлаа болдог. Үүний улмаас бусдыг хохироох юм уу шархлуулж мэднэ. Хэрэв та хүнийг ийм маягаар ялгаатай, хоёр нүүр гаргаж хандвал худал хуурмаг байдал гарахаас өөр аргагүй юм.

Үнэнч болоод хайр нигүүлсэлээр дүүрэн хүмүүс нь бусдын ямар ч дүр төрхийг хараад бусдыг шүүмжилдэггүй. Зүгээр л хайрын сэтгэлээр хүлээж авахыг хичээдэг. Нигүүлсэл нь хүмүүст амь амьдрал өгөх үр жимсийг төрүүлдэг бол ялгаварлах нь гомдол, шүүмжлэлээр үнэнийг гажуудуулж, хорон муугийн үр жимсийг төрүүлж, амиа алдахад ч хүргэдэг.

Есүсийн үед Фарисайчууд болон хуулийн багш нар Бурханы үгийг зааж сургадаг байр суурьтай байсан юм. Тэд хуулийг өөрсдийн зөв гэсэн туйлширсан үзлээр хуулийг тохируулан тайлбарлаж, ямар нэгэн зүйл тэдний бодсоноор болохгүй бол бусдыг буруутгаж гэмтэн гэж үздэг байсан.

Есүс амралтын өдөр өвчтэй хүнийг эдгээхэд дургүйцэж, амралтын өдрийг гутаан доромжилж зөрчлөө гэж байсан. ‘Амралтын өдрийг сахих’ гэдэг нь бүх ажлыг хийхийг тэр чигээр нь хорьж байгаа юм биш харин сүнслэг амралтыг хэлж байгаа юм. Өвчтэй хүнийг эдгээх, сайн мэдээ тарааж номлох, сүнс сэтгэлээ сэргээж өсгөх нь амралтын өдөр хийх ёстой сайн зүйл юм. Гэтэл фарисайчууд Есүсийг амралтын өдрийг зөрчлөө гэж шүүж байсан юм.

2. Ялгаварласнаар, худал хуурмагийн үр жимс боловсордог

Хүмүүс өөрсдийгөө өдөр тутмын амьдралдаа ингэж хэрхэн хоёр нүүр гаргаж байгаагаа болоод үүнээс үүдэн худал хуурмагийн үр жимс боловсорч байгаагаа ухаарч чаддаггүй. Жишээ нь эцэг эх нь ах дүү хоёр хүүхдүүдийг зэмлэхдээ ахаас нь “яагаад муудалцаад байгаан?” гэхэд “тэр эхлээд намайг цохисон!” гэж дүү рүүгээ заан хэлдэг. Энэ яриаг сонсвол дүү нь буруутай юм шиг санагдаж болох юм. Харин дүүгээс нь асуувал “Тэр миний тоглоомыг авах гээд байхаар нь би цохисон” гэж магадгүй.

Хэрэв эцэг эх нь ахын үгийг сонсоод зөвхөн дүүг нь л загнах юм бол дүүд нь ямар их хэцүү санагдах болоо? Эсвэл эцэг эх нь том хүүдээ илүү их хайртай бол эсвэл

дүү нь дандаа хэрэг төвөг тарьж байдаг бол ахад нь илүү их итгэнэ. Харин эцэг эх нь ухаалаг бол нөхцөл байдлыг үнэн зөвөөр хараад зөв шударга шийдвэр гаргах болно.

Үүнээс гадна өөрийн ашиг сонирхол, бодол санаанд нийцүүлэн үнэнийг гажуудах тохиолдол ч их байдаг. Ийм шинж чанар надад байвал би өөрөө ч мэдэхгүй худал үг яриа гардаг. Жишээ нь, таны хайртай нэг хүн буруу юм хийгээд буруутгагдаж байна гэж та сонслоо гээд төсөөлөөд үзье л дээ. Тэр үед “Үгүй ээ! Тэгэх учиргүй дээ” гээд итгэж чадахгүй юм уу “Тэгээгүй, тэр тийм хүн биш” эсвэл “Зайлшгүй тэгэх шалтгаан байсан” байх гээд яадаг ч байсан тэр алдааг нуух дарах гэж оролдох байх. Харин эсрэгээрээ ердийн үед дургүй хүн юмуу тухайн хүний талаар таагүй бодолтой явдаг хүний тухай түүний алдаа зөрчлийг сонслоо гэж бодъё. “Тэр урьд нь иймэрхүү алдаа гаргаж байсан. Энэ удаад дахиад л тэгжээ. Юу бодож явдаг хүн юм бол доо, ийт болохоор л надад таалагддаггүй юм” гэж бодон түүнд дургүйлэх сэтгэлийг улам дэврээдэг. Иймэрхүү ялгаварлах сэтгэл байгаа учраас үнэнийг олж мэдье гэхээсээ илүү элдэв үг ярианд шууд хүлээн аван, амархан итгэж, бусдыг дүгнэж шүүдэг.

Дахиад нэг жишээ авъя. Таны нэгэн танил хүн таны хажуугаар дуугарах ч үгүй, таныг үл тоомсорлосон янзтай өнгөрөөд явчихлаа. Тэр магадгүй маш гүн бодолд автсан эсвэл их завгүй явсан байж болно. Мөн их хүнд асуудалд ороод хэн нэгэнтэй ярихгүй байх зайлшгүй шалтгаантай байсан ч байж болно.

Ийм тохиолдолд бидэнд ялгаварлах үзэл байвал түүнтэй зөрөөд өнгөрөхдөө л шүүмжилж эхлэнэ. Түүний талаар бодохдоо “Ямар бүдүүлэг юм бэ? өмнө нь гуйсан зүйлийг хийж өгөөгүй болохоор тэгж байгаан болов уу?” гэж бодоод өөрийн бодол санаа болон сэтгэл хөдлөлдөө дүгнээд өнгөрөх болно. Ийм үед бид Ариун Сүнсний дуу хоолойг сонсож чадахгүй, нүд маань халхлагдаж, үнэнийг олж харах чадваргүй болдог байна.

3. Бүх зүйлд Бурханы мэргэн ухаанаар үнэнч байхын тулд

Нэгдүгээрт бид сул дорой, ядуу нэгнийгээ ялгаварлан гадуурхаж байна уу гэдгээ санах шаардлагатай (Египетээс гарсан нь 23:3). Ядуу зүдүү, сул дорой хүмүүс рүү биш бидэнд ашигтай хүчтэй, баян тансаг хүмүүсийн талд зогсож тал тохой татах ёсгүй.

Хүмүүс ихэвчлэн ядуу сул дорой хүн, хүчтэй баян хүн хоорондоо муудалцаж байвал аль сул доройгийнх нь талд орох нь зүйтэй гэж боддог. Харин Бурханы Үгийн дагуу бүх зүйлийг ялгаж салгаж чаддаг

байх хэрэгтэй. Аль нэг тал руу хэлбийлгүй нигүүлсэл ба хайрын нүдээр зөв буруу хоёрыг чин үнэнээр нь шүүж, ялгах хэрэгтэй.

Хоёрдугаарт, Шууд нүдээр харж, чихээрээ сонссон зүйл л биш бол зөвхөн сонссоноороо эсвэл хүмүүсийн амыг дагаж хөнгөн хуумгай шийдвэр гаргах ёсгүй. Хэрэв бидэнд ялгаварлах, хоёр нүүр гаргах сэтгэл байвал хичнээн үнэнийг сонсоод, бодит байдлыг шууд харсан ч жинхэнэ үнэн зөвөөр ялгаж салгахад хэцүү юм. Мөн бусдын үг яриаг л сонсон, өөрсдийнхөө ойлголт, бусдын талаарх таамаг дээр тулгуурлан дүгнэлт гаргавал маш том алдаа гаргаж болзошгүй юм. Тиймээс ямагт үзэж харж, сонссон бүхэндээ маш анхаарал болгоомжтой байж няхуур хандах хэрэгтэй.

Эцэст нь худал хуурмаг болон хоёр нүүр гаргахгүй байхын тулд шунаг сэтгэл болон муу мэдрэмж бүхий сэтгэл хөдлөлөө хаях хэрэгтэй. Ихэнх хүмүүс өөрт сайн ханддаг юмуу ойр дотныхоо хүндээ илүү сайн уян зөөлөн хандаад байдаг. Гэтэл ойр дотно байдаггүй хүн дүрэм журам зөрчвөл “ямар их биеэ тоосон, хүн бэ? бүдүүлэг юмаа” гэдэг гэтэл гэр бүлийнх нь юмуу дотно хүн ингэвэл “ингэх шалтгаан байсан биз. Яахав тэгээ л биз дахиж тэгэхгүй л бол болоо” гэж боддог, өнгөрөөдөг. Мөн хурал дээр өөрийн дургүй хүн санал дэвшүүлэхэд түүнийг элдэв шалтаг шалтгаанаар эсэргүүцдэг бол өөрийн сайн хүний саналыг үр дүнтэй дэмжих гэх мэт ханддаг.

Тиймд ямар нэгэн зүйлийн талаар хэлэхдээ бас бодохдоо ч ийм муу мэдрэмж бүхий сэтгэл хөдлөлдөө автан эсвэл шуналын сэтгэлээр хандаж байнуу гэдгээ эргэн харах хэрэгтэй. Ялангуяа энэ нь бидний хайртай хүн, дотны хүмүүстэй хамаатай бол бид илүү жинхэнэ хайрын сэтгэлээр бүх тал дээр үнэнчээр хэлж, үйлдэх хэрэгтэй. Гэр бүл, хамт олон, удирдлага, байгууллага гээд хэн ч байсан бүх хүмүүстэй илүү их анхааралтай харьцах хэрэгтэй. Нэг хэсэг нь зөв шийдвэр гаргалаа гэж байхад нөгөө хэсэг нь эсрэг байр суурьтай ч байдаг.

Хайрт итгэлийн ахан дүүс минь, Есүс шавь нартаа Матай 7:5 “Хоёр нүүрт хүн чи, эхлээд нүднээсээ дүгнээ авч хая, тэгвэл чи ах дүүгийнхээ нүднээс үртсийг авч хаяхдаа сайн харах болно” гэж айлдсан байдаг. Сүнслэг хайр бага тул хүмүүс ах дүүсийнхээ өчүүхэн зүйлсийг маш том гэм нүгэл болгон хардаг. Бид гэм нүгэл, хорон муугаа хаях тусам ариун болж, хүний жинхэнэ зүрх сэтгэлийг болоод нөхцөл байдлыг ялгаж салгаж чадна. Тиймээс, юуг ч сайнаар харж, сонсож, мэдэрч, бодсоноороо ямар үед төгс, зөв шударга байхыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Монгол Манмин Сүм

Мэргэлийн цаг

Мэргөл	Цаг
Их мэргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мэргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мэргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мэргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мэргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мэргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Та амьд оршигч Бурхантай уулзсан уу?

Үйлс 2-р бүлэгт гардаг анхны сүмд маш олон тэмдэгт гайхамшгууд элч нараар дамжуулан үзүүлж гайхалтай сэргэлт болж байсан. Өнөөдөр ч мөн Манмин Төв Сүмийн Тэргүүн Пастор И Жей руг пастораар дамжуулан олон тэмдэгт гайхамшгууд болон эрх мэдэлт хүчийг сургаалиар номлосоны дагуу батлан харуулж байгаа билээ. Үүнийг харсан асар олон хүн амьд оршигч Бурхантай уулзаж, авралын баталгааг олж аваад эдгэшгүй өвчнөөсөө эдгэрч, хүнд хэцүү асуудлаа шийдвэрлэж байгаа билээ. Тийм хүмүүсийн гэрчлэлүүдээс дурдъяа.

“Удаан үргэлжилсэн ган тайлагдсан нь”



2009 оны 9 сарын 6, 7 нд И Жей руг пастор Израйлийн төв хэсэг Иерусалимд нээгдсэн Эдгэрлийн нэгдсэн их цуглааны үеэр Даниел Розен пастор улс оронд нь нүүрлээд байгаа маш хуурай ган гачигийн төлөө залбирч өгөхийг гуйжээ. И Жей руг пастор энэ залбирлын хүсэлтийн төлөө номлолын дараа эдгэрлийн залбиралтай хамт залбирал

хийсэн юм. Нэгдсэн их цуглаан дууссаны маргааш буюу 9 сарын 8нд их хэмжээний хүчтэй бороо орж эхэлжээ. Энэ үйл явдал Израйлийн олон нийтийн телевизээр гарч маш олон хүний гайхшралыг төрүүлсэн байна.



“Энэ бол гайхамшиг! Шинэ мах төлжиж хэвийн байдалд орсон”

Ким Өн дүг халамжлагч нь биен дээр буцалж байсан том халуун тогоотой ус асарч бүх бие 3-р зэргийн түлэгдэлттэй эмнэлгийн аргаар бол эдгэрэх ямар ч боломжгүй болсон байлаа. И Жей руг пасторын залбирлаар халуун нь бууж, цоо шинэ мах төлжин шинээр ургаж маш гайхамшигтайгаар эдгэрсэн. Тэр одоо цоо эрүүл болсон байна.



“Би ДОХ өвчнөөс эдгэрсэн”



Лалита хүний наймаачны гарт орж Мумбай руу зарагдаад нэг цагдаагийн ачаар арайхийж тэдний гараас мултгарч бөөн баяр болсон хэдий ч аль хэдийнээ ДОХ өвчин авсан байлаа. Тэр маш их сэтгэлээр унаж, гутарч амиа хорлох тухай боддог байв.

2002 онд Энэтхэгт Эдгэрлийн нэгдсэн их цуглаан болох талаар сонсоод оролцжээ. И Жей руг пастор сургаал номлосныхоо дараа эдгэрлийн залбирал хийхэд тэрээр маш хурц гэрэл харж, бүх биеэр нь цахилгаан цохих мэт гайхамшигтай мэдрэмж төрсөнийг мэдэрчээ. Цуглааны дараахан шинжилгээ хийлгэхэд эрүүл гарч эмч нар хүртэл гарцаагүй Бурханы л хийх ажил гэж хэлжээ.



Галиани Эмнэлэгийн Эмгэг судлалын клиникийн захирал Симон


“Зүүн талын улаан шугам нь нааштай гайгүй байна гэсэн үг харин түүний шинжилгээний хариу нь одоо баруун талд байна. Одоо тэр зүв зүгээр хэвийн болсон байна. Энэ бол Бурханы хийсэн ажил гэдгийг үгүйсгэхгүй аргагүй юм! Бурхан бол төгс хүчит билээ” гэжээ.

“Хавдрын эс юу ч үгүй алга болсон!”



Ким Гим хёон сүмд үйлчлэгч Чоннам үндэсний их сургуулийн Хуасун эмнэлэгт Булчирхайн хавдар 3-р үедээ орсон байна гэж оношлогджээ. Эмч нь түүнийг хавдрын эсрэг эмчилгээг наймаас дээш удаа хийлгэх тухай зөвлөсөн юм. Тэрээр хэдийгээр сүмд ирээд удаагүй байгаа ч хавдрын хоёр дахь удаагийнхаа эмчилгээг хийлгэж байхдаа Бурханы өмнө

гэмших сэтгэл төржээ. Учир нь сүмд Бурханы эрх мэдэлт хүчний нөлөөгөөр олон хүнд өвчтнүүд эдгэрсэн тухай харж, сонсож байсан учраас юм. Тиймээс ч Бурханы өмнө өөрийгөө бүрэн зориулахаар шийдэн, зүрх сэтгэл, цэгцлээд И Жей руг пастораас залбирал авсан юм. Хоёр өдрийн дараа эмнэлэгт очин шинжилгээ хийлгэхэд гайхалтай нь хавдрын эс юу ч үгүй алга болсон байлаа!



- ▲ Залбирал авсаны дараа Сонсох чадвар сайжирсан, чих шуугих байдал арилсан
- ▲ Залбирлын өмнө Хавдрын эс маш олон газар тархсан байгаа нь
- ▲ Залбирлын дараа Хавдар байхгүй болсон байгаа нь

“Бараг юу ч сонсож чаддаггүй байсан чих маань сонсдог болсон”

Давид Гонзалесийн зүүн чих нь бараг юу ч сонсдоггүй, радио нэвтрүүлгээ программыг хөтлөхдөө бусадтай ярьж чадахгүй маш хэцүү байдаг байлаа. 2006 оны Нью Йоркын нэгдсэн их цуглаанд оролцож И Жей руг пасторын залбирлыг авах үед толгойноосоо хөл хүртэл сэрүүн оргихыг мэдэрч, зүүн чих нь юм сайн сонсож эхэлжээ.



“Хэвлий дэх урагт үүссэн гаж хөгжил хэвийн болсон!”

Им Жон э сүмд үйлчлэгч 4 сартай жирэмсэн байхдаа (QUAD) ургийн нарийн шинжилгээнд оржээ. Шинжилгээгээр Дауны хам шинж, Едвардын синдром хоёулаа хосолж хромсомууд нь маш их хэмжээтэй гарч гажигтай ураг байгаа нь батлагджээ. Харин И Жей руг пасторын залбирлаар Жихо гэдэг эрүүл саруул хүүтэй болжээ. Бурхан агуу их хүч чадлаараа ургийн гаж хөгжил бүхий асар олон триллион эсүүдийг хормын дотор өөрчилж хэвийн болгосон байна.



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин


“Би нүдний болор үрэвсэх өвчнөөс эдгэрсэн”





Юү Ёон ми сүмд үйлчлэгчийн зүүн нүд гэв гэнэт харанхуйлан, хараа нь маш хурдан муудсан юм. Түүний нүдэнд юм сайн харагдахгүй бүрэлзээд, мөн харагдаж байгаа зүйлүүд шар төвийсөн хэлбэртэй, шар өнгөтэй болж харагдаад заримдаа бүр юу ч харахгүй, дотор нь муухайраад бөөлждөг болжээ. Ингээд эцэст нь эмнэлэгт очиж шинжилгээ хийлгэхэд нүдний болорын үрэвсэл гэж оношлогдсон байна.

Эмч түүний нүдэнд нь уйланхай үүссэн тул эмчилгээ хийгээд ч хараа нь эргээд хэмийн хэмжээнд ортлоо сэргэх хэцүү гээд хэрэв тэр уйланхай нь улам томорвол харааны мэдрэлийг дарж, хараагүй болох болно гэжээ. Гэсэн ч И Жей руг пасторын залбирал бүрэн эдгэрч одоо жижиг бичсэн үсгийг ч сайн харж, өнгөний ялгааг хүртэл маш сайн ялгадаг болжээ.

• Залбирал авахын өмнө



• Залбирлын авсаны дараа



▲ Залбирлын дараа: хоёр нүдний уйланхай нь алга болсон, нүдний хараа нь 0.8/0.25-аас 1.0/1.0, хүртэл сайжирсан бөгөөд нүдний торлог бүрхэвчний өвчин нь хүртэл эдгэрсэн байна.

“Би атопи өвчнөөс цэвэрхэн эдгэрсэн”



Ким Су бин эгч дүүс 4 настайгаасаа эхлээд атопи арьсны үрэвсэлт өвчнөөр өвчилж эхэлсэн юм. Тэрээр ахлах сургуульд байхдаа идээлж, хавдсан нүүрээ нуун халуун зунаар ч дандаа маск зүүдэг байжээ. Энэ байдал оюутан болсон хойно нь өвчин нь улам хүндэрсэн байна. Тэрээр өөрийн өнгөрсөн үйл явдал, итгэлийн амьдралаа эргэн харж, Бурханы дургүй дэлхийн зүйлээс таггалзаж, чин сэтгэлээсээ гэмшиж И Жей руг пасторын өвчин эдгээх залбирал авсан байна. Залбирлын дараа түүний өвчин бүрэн эдгэрчээ.




“Би олон салаат тархины судасны хатууралт өвчнөөс эдгэрсэн”



Эдвард Гурерро сайн явж чаддаггүй, хараа муу учраас тэнцвэрээ олоход хэцүү, сонсгол муутай байсан байна. Тэр тархины олон салаат судасны хатуурал гэдэг эдгэшгүй өвчтэй гэж оношлогджээ. Насан туршдаа тэрээр эм уух л арга зам байлаа. 2004 оны Перуд болсон Эдгэрлийн нэгдсэн их цуглаанд оролцож, И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлыг аваад тэнцвэрээ сайн олж явж чаддаг болоод зогсоогүй нүдний хараа нь сайжирч, бүр сайн сонсдог болжээ. Эдгэрлийн цуглааны тэрээр эмнэлэгт очин шинжилгээ хийлгэхэд тархины MRI бичлэгт тархины судасны үрэвсэл болон ямар ч өвчний шинж тэмдэг байхгүй байна гэсэн хариу гарчээ.



▲ Залбирал авахаас нэг жилийн өмнөх тархины MRI бичлэг
Тархины судасны өвчтэй байгаа нь



▲ Залбирал авсны дараах MRI бичлэг
Тархины судасны үрэвсэл харагдахгүй байгаа байдал

“Гэрлэсэнээс хойш 10 жилийн дараа хүүхэдтэй болсон”

Асиф Назир пасторын эхнэрийн үр дамжуулах суваг нь бөглөрсөн учраас хүүхэдтэй болох боломжгүй байлаа. Тэд Солонгост ирж И Жей руг пасторын залбирлыг авах хүсэлтэй байсан ч виз нь бүтээгүй учраас зургаа явуулж залбирлын хүсэлтээ явуулан И Жей руг пастораас залбирал авчээ. Түүний дараахан 10 жил хүүхэдтэй болж чадахгүй байсан түүний эхнэр жирэмсэлж хүүхэдтэй болжээ.



“Татаж унан, ухаан алдсан байсан ч залбирал авсан даруйдаа боссон юм”

Жоел Раммос зүрхний хэм алдагдалтай учраас зүрхний ажиллагаа хэвийн биш, залуу байхаасаа л унаж татдаг өвчтэй байжээ. 2001 онд Филиппинд болсон Эдгэрлийн нэгдсэн их цуглаанд оролцож байхад бие нь гэв гэнэт ухаан алдаж, бие нь хөшиж яг л үхсэн хүн мэт болжээ. Түүнийг И Жей руг пасторын өмнө дамнуурган дээр тавин авчирахад тэрээр хийж өгөхөд тэр залуу тэр даруй босч, явж чаддаг болсон байна.



“Хүчирхэг зуучлан залбиралаар үерийн аюулаас гэтэлгэгдсэн нь”

Мике Куипер доктор Австралид болсон WCDN (Дэлхийн Христэд итгэгч Эмч нарын холбоо)-ийн их хурлаас 2011 оны 1 сарын 12 нд Солонгос руу И Жей руг пасторт хандан залбирч өгөх хүсэлт явуулжээ. 2010 оны 12 сарын эхээр Квейнланд-д асар их үер бууж Брисбан голын түвшин 8 метр болж хотын захын байшингууд үерт автаж байлаа. Харин И Жей руг пасторын залбирлаар бороо зогссон билээ.



Хэрэв тэр голын түвшин улам ихэсвэл мянга мянган байшин үерт автах болно гэж цаг агаарын мэдээгээр мэдээлж байлаа. И Жей руг пасторын залбирал ямар хүчтэй болохыг хараад зүрх минь догдолж чин сэтгэлээсээ талархалаа илэрхийлсэн билээ.



2011 оны 1 сард Австралийн Квейнландын үер.

Date	Day	Temps		Rain	Evap	Sun
		Min	Max			
1	Sa	21.7	28.4	0.4	6.6	0.0
2	Su	22.7	29.6	3.0	2.2	11.2
3	Mo	22.9	32.1	0	6.2	6.9
4	Tu	22.2	30.7	0	5.4	7.8
5	We	21.7	29.3	0	5.2	0.0
6	Th	20.5	24.8	41.8	4.6	0.0
7	Fr	19.3	28.8	35.6		0.8
8	Sa	21.1	27.3	11.6	2.0	2.1
9	Su	22.0	27.8	12.2	2.4	
10	Mo	22.5	27.1	110.8	1.4	
11	Tu	23.8	28.6	15.4	2.0	0.0
12	We	21.9	29.6	40.0	2.4	
13	Th	22.1	28.4	0.4	7.8	6.9
14	Fr	19.4	28.9	0	8.2	11.8
15	Sa	20.2	28.8	0.4	7.2	9.2
16	Su	19.5	29.7	0	6.2	
17	Mo	19.5	33.5	0	7.0	
18	Tu	23.2	34.9	0	7.2	10.1
19	We	23.4	31.2	3.4	4.6	10.3

1 сарын 13 залбирал хийсний маргааш бороо зогсож ус татарч буй байдал.